

гол нутагт сэм нэвтрэн ирж, Алтан уул, Онгон-Улаан, Хярын гүн худаг, Нүхэнгийн нуруу, Той тогос зэрэг алтны ордтой газрын алтыг малтаж тунгаан авч буйг нутгийн ардууд мэдээд энэ тухай мэдээг Түшээт хан аймгийн чуулганы газарт дамжуулсанд, чуулганы дарга агсан Мишиг даа гүн, тус аймгийн жанжин нар нэн түргэн цэрэг татан дайчилж, дээр дурдсан алтны орд уурхайнуудаар довтлон явж, тэдгээр нанхиад иргэнийг баривчлан, тэдний олзлон авсан бүх алтыг нэгд нэггүй хураан авч улсын санд оруулаад, Нанхиад иргэдийг цэргээр туулган өмнөд хил давуулан хөөж орхижээ. Хөөгдсөн иргэд нутагтаа очоод, манжийн хаанд айлтгал бичиж, гомдол мэдүүлэн өргөхдөө, манж, монгол, нанхиад гурван үндэстэн нийлж нэгдсэн Чин гүрэн гэдэг нэгэн улс байтлаа нэг үндэстэн нь нөгөө үндэстнийхээ нутагт орж яагаад болдоггүй юм бэ?, газрын баялагийг ашиглаж яагаад болдоггүй юм бэ? гэх зэргээр мэдүүлжээ.

Монгол нутагт нанхиад иргэд орж, газрын баялгийг олзлон авч үл болох тухай эл хэргийг нэгэн тийш болгон таслан шийтгэж гүйцэтгүүлэхээр манжийн хааны шадар сайдын нэг Пүн Жунтанг зарлигаар томилон Да Хүрээний зүг мордуулжээ.

Пүн Жунтан Богдын хүрээнд ирээд, гадаад, дотоод, цэрэг, сан, түүх зэрэг таван яамны бичиг зохиох зэрэг эрхэлсэн түшмэдүүдийг цуглуулаад, Монгол нутагт хятад хүмүүс орж ирэн газрын баялгийг малтан авч ашиглаж үл болох учрыг болон олзолсон алтыг хурааж тэдгээр иргэнийг хил давуулж хөөсөн зэрэг хэргийн учир шалтгааныг хүн бүр дэлгэрэнгүй тодорхой бичиж авчрах тухай даалгав.

Хэд хоногийн дараа үүрэг даалгавар авсан түшмэдүүдийг дуудан цуглуулж, хүн бүрийн бичсэн эхийг шалган үзтэл олонхи нь манай Монгол нутгийн лус савдаг их догшин, маш хэцүү тул хятад иргэд орж ирэн, ашигт малтмал олох гэж газар ухвал лус савдаг дошгирч, хангай тэнгэр хилэгнэн цахилгаан цахих, аянга буух, тэнгэр ниргэх, ган зуд болох зэргээр аюул болж хүн мал сүйрч хэлмэгдэнэ гэх мэтээр бичсэн байжээ.

Тэр олон эх бичгийн дотор Цэцэн хан аймгийн дайчин бээсийн хошууны (одоогийн Хэнтий аймгийн Батноров сумын) Галсандоной. хурцын бичсэн эх бичиг огт өөр утга агуулгатай байсан агаад түүний бичсэнийг доор дурдвал:

«Манжийн хаан бол тэнгэрийн хөвгүүн, алтан лууны зулзага бөгөөд бидний монголчууд тэнгэрийн хөвгүүн алтан лууны зулзагын үхэр, тэмээ, хонь, адуу зэрэг өндгөн сүргийг маллах малчин ард болой. Тэнгэрийн хөвгүүн алтан лууны зулзагын өндгөн сүрэг бол малтан ухаж нүх сүв, суваг шуудуу гаргаагүй атар сайхан нутагт дур зоргоороо бэлчээрлэн тарга тэвээр авч байх ёстой.

Хэрэв хятад иргэд олноор орж ирэн газар ухаж, нүх сүв, суваг туудуу гаргах зэргээр газрын хөрс эвдвэл, түүнд хөр цас хунгарлаж, мал сүрэг унаж үхэх, сүргийн бэлчээрийн өвс арилах, тэр олон хүн хааны өндгөн сүргээс идэж хороох тул гаднаас олон хүн ам оруулахгүй байх явдал нэн чухал байна» гэжээ.

Пүн Жунтан ч Галсандоной хурцын бичсэн эх бичгийг сонгон авч сийрүүлэн бичиж, үсэг зуруулж, тамга даруулж аваад буцжээ.

Хэдэн сарын дараа Бээжингээс элч бичиг довтлон ирсэн бөгөөд тэр бичигт манж хааны өндгөн сүргийг малласан монгол нутагт олз

омог хайсан олон хүнийг оруулж, газар ухуулж, түүний баялгийг авахуулахгүй байх явдал нэн чухал, зөв зүйтэй хэрэг тул Монголын өмнөд хилээс Алтай, Ил тарвагатай хүртэл алтны 21 харуул байнга суулгаж, сэмхэн орж ирэх иргэдийг сэргийлэн, алт сэлтийг авахуулахгүй цагдан сэргийлж байсугай хэмээжээ. Үүний дагуу суулгасан 21 харуул ардын хувьсгал үүстэл байж байв.

Үүнээс гадна мөн ийм нэгэн явдал болжээ.

Манжийн үед эдүгээгийн Амгаланбаатар хотноо заргачийн яам гэдэг хэрэг зарга шүүн таслах яам байсан хийгээд түүнд гол төлөв монгол, хятад иргэдийн хоорондох өр шир, өглөг авлага, хулгай дээрэм хийгээд ам гэрээ хэлэлцээний улмаас үүссэн иргэний болон эрүүгийн хэрэг заргыг үнэнээр нь нэгд нэггүй нарийн чанд илчлэн олж, нэгэн тийш болгож, таслан шийтгэдэг яам байжээ.

Тэр яаманд хэрэг таслан шийтгэх цаг тухай бүрд, монголын таван яамнаас тус бүрд нэг түшмэл ээлжээр очиж, уг хэргийг мөрдөн байцаалцаж, таслан шийтгэлцэх зэрэг хэрэгт байнга оролцдог журамтай байв.

Заргачийн яаманд хэрэг зарга байцаан шүүж, таслан шийтгэдэг манж, монгол, хятад гурван түшмэлийн өргөө гэрийн хоймор гурван олбог түшлэг байвал зохих атал тэнд зөвхөн манж, хятад хоёр түшмэлийн олбог түшлэгийг тавиад, монгол түшмэлийн олбогийг баруун хатавчнаас арай хойгуур дэвсэж хэрэг таслуулах иргэдийг гэрийн үүдэнд сөхрүүлэн байж хэрэг тасалдаг журам хэзээний үргэлжилсээр байжээ. Хэрэг зарга байцаан шүүж таслахдаа хятад иргэдээс хээл хахууль ил далд авч амташсан манж түшмэд ямагт тал тохой татаах, хятад иргэдийн хэргийг зөв болгож, монголын түшмэлийн үгийг үл хэрэгсэх зэргээр хавчин гадуурхах явдал байнга гаргаж байв. Заргачийн яаманд ажиллаж байсан монгол түшмэд энэ тухай хүүрнэлдэн байхыг Галсандоной хурц сонсмогц, —яана, яана гэнээ хөө! Яасан задарсан хар тархинууд вэ хө. Намайг нэг ээлжинд нь явуулаарай гэхэд цөм баярлан, — за тэье гэгцгээв. Хэд хоногийн дараа Галсандонойн суух ээлж болмогц нэг өглөө тэрбээр тус яаманд хүрэлцэн очиж, ороод шууд манж, хятад түшмэлийн олбог түшлэгэнд суутал, танай суудал энэ биш, тэр байна гэж монгол түшмэлийн олбогийг заажээ.

— Аа тийм үү, би энд суудаг эрхтэй хүн гээд, босохгүй байхад нь манж, хятад түшмэл зандрэн уурлаж, хэрүүл шуугиан болжээ. Галсандоной босч, тэдний олбог түшлэг, ширээ сандал сэлтийг шидлэж, тэднийг болон хэрэг таслуулах иргэдийг хөөн гаргаж, өнөөдөр хэрэг таслахгүй дараа ирцгээ хэмээн тарааж гэнэ.

Галсандоной буцаж ирмэгц эх бичиг зохиож хуулуулан хүрээний монгол сайдаар үсэг зуруулж тамга даруулан өртөөгөөр эзэн зургаанд яаралтай илгээжээ. Түүнээс хойш нэн удалгүй эзэн зургаанаас бичиг ирсний дотор дурдсан нь: Заргачийн яаманд манж, монгол, хятад түшмэл нэгэн адил тэгш эрхтэй байх журамтай тул манж түшмэлийн хоёр хажууд монгол, хятад хоёр түшмэлийн олбог түшлэг байх ёстой. Аливаа хэрэг шийтгэн таслахдаа бүгд эрх тэгш бөгөөд хэрэгтэн нараас асуух, байцаах, таслан шийтгэх зэрэг явдлыг цөм бүрэн эрхтэй гүйцэтгэх ёстой. Урьдын адил монгол түшмэлийг ялган үзэж хэрхэвч үл болно гэжээ.

Манай Монгол нь манжийн ноёрхолд байхдаа ч эрх чөлөөгөө энэ мэт эрмэлзэн тэмцсээр, тэдний дур зоргоороо загнах эрх сүрийн дор

алга хавсан шүтэж, байгалийн баялагаа цөлмүүлж номхон хүлцэнгүй суугаагүй, харин хөрсөн дорхи болоод дээрх аливаа хөрөнгө агуурсад минь хүйтэн цэвдэг хандах элдэв хандлагын илрэлтэй эр зоригоор, арга ухаан, эр чадал аль алиныг гарган тэмцэж байжээ.

2. Дагвасамбуу захирагчийн шийтгэсэн хэрэг

Олноо өргөгдсөний үед Түшээт хан аймгийн Эрдэнэ ван, Баатар ван, Дайчин ван зэрэг гурван хошууны ноёд, түшмэд Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөөгийн аль сайхан үржил шимтэй олон булан тохойг хятадын тарианы пүүснүүдэд өндөр үнээр түрээслэн өгч, олсон ашгийг өөрсдөө завшиж эхэлжээ.

Тэр олон булан тохойд хэзээнээс нааш буудай, хошуу, халтар арвай, чангаамал тарьж, амь тэжээн, алба барьж байсан орон нутгийн ардуудад тариа тарих газар бага болж, хятадын тариан дундуур орсон оодонгийн үхрийг хятадууд хадуураар цавчин хөөснөөс үхэр шархлан өгөх болжээ. Орон нутгийн тариачин, малчин ардууд энэ тухай гомдлыг нийслэл хүрээнээ дотоод, шүүх зэрэг яамдад мэдүүлжээ. Тэдгээр яам уг хэргийг байцаан үзээд, Богд хаанд уг учир явдлыг айлтгахад, дээр дурдсан гурван ванг нутагтаа нэг газар цугларан яамлаж, газраа түрээслүүлсэн тухай хэрэг шийтгэх зарлигийн сайд хүрэлцэн очтол хүлээн сууж байх, Сайн ноён хан аймгийн Балдан засгийн хошуу захирагч Дагвасамбууг зарлигийн сайдаар томилон эл хэргийг таслан шийтгэх зарлиг буулгажээ.

Нэн их удалгүй зарлигийн сайд Дагвасамбуу өртөө, улаагаар довтлон, гурван вангийн яамалсан улаан халзан өргөөнд хуучин үзүүрсгэн дээлтэй, үнэгний годон хуучин малгайтай тэрбээр орж очиход, гурван ван — Алсаас ирсэн арьсан дээлтэй түшмэл (зарлигийн сайд) мэнд үү? гэж мэндлэхэд, Дагвасамбуу:

— Газраа худалдаж гахай шиг таргалсан ноёд мэнд үү? хэмээн хариу мэндэлжээ.

Зарлигийн сайд Дагвасамбуу тэрхүү гурван ванг тус бүр тав, таван зуун лангаар торгож, нэвсэртэл донгодон, хойшид газраа түрээслэх эрхгүй болгон шийтгэжээ.

Дээр үеийн засаг хошуудын захирагч, туслагч, залан, мээрэн тушаалтай дөрвөн түшмэлийн захирагч нь тэдний ахлагч бөгөөд гол төлөв бичиг үсэг сайтай ард хүнийг захирагч болгодог хэв журамтай байжээ.

Дагвасамбуу захирагч олон янзын баримт хэргийг үнэнч шударгаар таслан шийтгэж явсан эх оронч ард хүн байжээ. Ийнхүү манай ард түмэн эх нутгийнхаа ариун сайхан байгалийг хамгаалахын тул элдэв аргаар тэмцэж иржээ.

Эцэст тэмдэглэх ину: Манай зарим шинжээч судлагчид ямар нэгэн ашигт малтмалын хайгуул хийж явахдаа төмөр, зэс, тугалга, болор гэх мэт ашигт малтмалын орд уурхайг эрт цагт малтан ухаж байсан хонхор нүхийг үзэнгүүтээ хятадууд л ухаж авч байж гэсэн дүгнэлт хийвэл хэт өрөөсгөл талтай болох буйзаа. Учир юу гэвэл, Хятад улс нь Монгол улсын харьяанд удтал байсан ба монгол улс нь хятад улсын харьяанд хэзээ ч байгаагүй бөгөөд харин 1919-1920 онд манай монгол улс хятад улсын харьяанд түр зуур байсан нэртэй боловч хятад иргэд, гамин цэрэг монголын ардын журамт цэ-

рэгт хөөгдөн амь наана там цаана зугатаж явсан тул тээврийн хэрэгсэл төдий л хөгжөөгүй тэр үед их говийг гатлан газрын баялаг ашиглах байтугай амь зулбах замдаа тохиолдсон ард иргэдийг алж хядаж өнгөрсөн.

Учир иймд манай эх орны ашигт малтмалаас хятад өөрийн дураар авч ашиглаж байсан нь асар их биш бөгөөд монголчууд тэгж дуранд нь тавьж байгаа ч үгүй, харин болор зэргийг сангийн яам нийслэл дэх монгол, хятад зэрэг ядуу хүмүүсийг хөлслөн авч ухуулан гаргасан болор зэрэг чулуугаа нийслэл хүрэн дэх чулуу эрдэнийн пүүсэнд худалдан, тэр пүүс худалдаж авсныгаа урагшаа тээдэг байсан юм. Манай эх оронд байдаг хэдэн зуун зэсийн ордыг аль эрт цагт Азийн төвөөр амьдарч байсан монгол, кидан, түрэг, уйгар зэрэг олон овог аймгийн хүмүүс хүрэл зэвсгийн үеэс зэс, цайр, тугалга тэргүүтэй ашигт малтмалаар хүрэл зэвсгээ хийж амьдарч ирсэн баялаг түүхтэй билээ.

**ЧИНГИС ХААН ТЭМҮҮЖИН ИИ МЭНДЭЛСНИЙ
800 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН БОСГОСОН ГЭРЭЛТ
ХӨШӨӨГ ХҮЛЭЭН АВАХААР ЯВСАН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ**

Н. Ишжамц

Энэ 1962 оны 2-р сарын 14-ний өдөр МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос Монголын тулгар төрийг үндэслэн байгуулагч Чингис хаан Тэмүжиний мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэж өнгөрүүлэх тухай тогтоол гарсан билээ.

Шинжлэх ухааны Академийн Түүхийн хүрээлэн 1962 оны 5-р сарын 31-ний өдөр Чингисийн төрсний 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал хийв.

Мөн тэр үеэр Хэнтий аймгийн Дадал сумын нутаг Гурван нуурын амралтын дэргэд Чингисийн хөшөө сүндэрлэн босч байв. Удалгүй уг хөшөө бэлэн болж Шинжлэх ухааны академи хүлээн авах асуудал гарав.

1962 оны 6-р сарын 26-ны өдөр Академийн тэргүүлэгчийн хурал болж оны эхний хагасын ажлын дүн хэлэлцэж байгаад завсарлах зуур Академийн ерөнхийлөгч Б. Ширэндэвээс намайг Чингисийн хөшөө хүлээн авах ажилд томилсон тухай мэдэгдлээ. Мөн асуудлын талаар Академийн дэд ерөнхийлөгч Б. Дашжамц Түүхийн хүрээлэнгийн захирал Ш. Нацагдорж нар намайг дуудаж ярилцан зохих заавар өгөв.

27-ны өдөр явах замын маршрут гаргаж батлуулах зэрэг бэлтгэл ажил хийв. 28-нд Барилгын яаман дээр очиж, Чингисийн хөшөө барих ажлыг удирдсан залуу мэргэжилтэн Чойжамцтай уулзлаа. Энэ хөвгүүн надтай хамт Гурван нуур явж уг хөшөөг хүлээлгэн өгөхөөр